



**Монгол Улс: Ухаалаг засаг-2 төсөл**

## **БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ (БОНХТ)**

**Цахим хөгжил, харилцаа холбооны яам**

Төсөл хэрэгжүүлэх нэгж

2024 он

1. Цахим хөгжил, харилцаа холбооны яам (ЦХХХЯ) нь “Ухаалаг засаг-2” төслийг (P176631) Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Авлигатай тэмцэх газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын хамтын оролцоотой хэрэгжүүлнэ. Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци (цаашид Банк гэх) уг төслийг санхүүжүүлнэ.
2. ЦХХХЯ нь төслийг Байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС)-д нийцүүлэн хэрэгжүүлэхийн тулд бодит арга хэмжээ авч, үйл ажиллагаа хэрэгжүүлнэ. Энэхүү Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөө (БОНХТ)-нд бодит арга хэмжээ, үйл ажиллагаа, аливаа тодорхой баримт бичиг, эсхүл төлөвлөгөө, түүнчлэн эдгээрийг нэг бүрчлэн хэрэгжүүлэх цаг хугацааг тусгана.
3. ЦХХХЯ нь БОНХ-ний дагуу шаардагдах, мөн энэхүү БОНХТ-нд дурдагдсан Байгаль орчны асуудлаар баримтлах журам (БООАБЖ), Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журам (ХХЗЖ), Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ) зэрэг бусад аливаа Байгаль орчин, нийгмийн асуудал тусгагдсан баримт бичгийн заалтууд болон БОН-ийн баримт бичгүүдэд заасан хугацааг мөрдлөг болгоно.
4. ЦХХХЯ нь дээрх 1-д иш татсан яам, агентлаг, албаны зүгээс хэрэгжүүлсэн тодорхой арга хэмжээ авч, үйл ажиллагаанд БОНХТ-ний бүхий л шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй.
5. ЦХХХЯ нь БОНХТ-д тусгасан бодит арга хэмжээ болон үйл ажиллагааны хэрэгжилтэд БОНХТ-ний шаардлага болон хууль ёсны хэлэлцээрийн нөхцлийн дагуу хяналт тавьж, энэ талаар Банкинд тайлагнах ба Банк нь төслийг хэрэгжүүлэх явцад авсан бодит арга хэмжээ, үйл ажиллагааны явц, гүйцэтгэлд хяналт тавьж, үнэлгээ хийнэ.
6. Төслийн хэрэгжилтийн явцад гарах өөрчлөлт, урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал үүсэх, эсхүл БОНХТ-ний хэрэгжилтийн хүрээнд төслийн гүйцэтгэлийг үнэлсэнтэй холбоотойгоор Банк болон ЦХХХЯ хооронд тохиролцсоны дагуу БОНХТ-г шинэчилж болно. Ийм тохиолдолд, уг төлөвлөгөөнд оруулах өөрчлөлтийг ЦХХХЯ нь Банктай зөвшилцөж тохиролцсоны үндсэн дээр БОНХТ-нд тэдгээр өөрчлөлтийг тусгана. БОНХТ-нд оруулахаар харилцан тохирсон өөрчлөлтийн талаар Банк болон ЦХХХЯ хооронд гарын үсэг бүхий албан бичиг солилцож баримтжуулна. ЦХХХЯ шинэчилсэн БОНХТ-г нэн даруй олон нийтэд ил тод мэдээлнэ.
7. Төслийн хэрэгжилтийн явцад гарсан Төслийн өөрчлөлт, урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал эсхүл төслийн гүйцэтгэл нь эрсдэл болон үр нөлөөг өөрчилсөн тохиолдолд ЦХХХЯ-ны зүгээс шаардлагатай гэж үзвэл байгаль орчин, олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын нөлөөлөл, ажиллах хүчний үрсгал, эмзэг бүлгийг гадуурхах гэх зэрэг төсөлд хамааралтай эрсдэл, нөлөөллийг арилгах арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт санхүүжилтээр хангана.

БОДИТ АРГА ХЭМЖЭЭ БА ҮЙЛ АЖИЛЛАГАА		ХУГАЦАА	ХАРИУЦАХ ЭТГЭЭД/ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА
<b>ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ БА ТАЙЛАГНАЛТ</b>			
А	Төслийн байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүйн ажиллагаа (БОНЭМАА)-ны гүйцэтгэлд хийсэн хяналт шинжилгээний тайланг тогтмол бэлтгэж Банкинд ирүүлэх ба уг тайланд тусгах асуудал БОНХТ-ний хэрэгжилт, БОНХТ-ний дагуу шаардагдах байгаль орчин, нийгмийн асуудлаарх баримт бичгүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлын явц, талуудын оролцоог хангах үйл ажиллагаа, өргөдөл, гомдол барагдуулах механизмын ажиллагаа зэргээр хязгаарлагдахгүй.	Төсөл хэрэгжих бүхий л хугацааны туршид 6 сар тутам	ЦХХХЯ, ТХН
В	Төсөлтэй холбоотой аливаа тохиолдол, осол гэмтэл гарсан, эсхүл байгаль орчин, нөлөөлөлд өртсөн иргэд, олон нийт болон ажиллагсдад ихээхэн сөрөг нөлөө үзүүлсэн, эсхүл үзүүлж болзошгүй тохиолдолд, энэ талаар Банкинд нэн даруй мэдэгдэнэ. Тухайн тохиолдол эсхүл осол гэмтлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгөхийн зэрэгцээ тухайн тохиолдолд авсан, эсхүл авахаар төлөвлөж буй арга хэмжээ, мөн холбогдох гэрээт ажил гүйцэтгэгч, хяналт тавих байгууллагаас зохих ёсоор өгсөн бүхий л мэдээллийг ирүүлнэ. Улмаар, Банкнаас шаардсаны дагуу тухайн тохиолдол, эсхүл осол гэмтлийн талаарх тайланг бэлтгэж, үүнийг дахин давтагдахаас сэргийлэх аливаа арга хэмжээг санал болгоно.	Тохиолдол/осол гэмтлийн талаар олж мэдсэнээс хойш 48 цагийн хугацаанд багтаан Банкинд энэ талаар мэдэгдэнэ.	ЦХХХЯ, ТХН
<b>БОНС 1: БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ЭРСДЭЛ БА НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ, УДИРДЛАГА</b>			
1.1	<b>ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ</b> Төсөл хэрэгжүүлэх нэгжид хамгийн цөөндөө Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцах нэг мэргэжилтэн томилох, эрэлт хэрэгцээнд тулгуурлан хөндлөнгийн зөвлөх багийг гэрээлэн ажиллуулах зэргээр байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежмент хийх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чадварлаг ажилтан, нөөц бүхий зохион байгуулалтын бүтэц бүрдүүлнэ.	Төсөл хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэнээс хойшхи 30 хоногийн хугацаанд багтаан дор хаяж энэ чиглэлээр ажиллах байгаль орчин, нийгмийн нэг мэргэжилтнийг томилох ба байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөх багтай гэрээ байгуулж ажилд нь оруулсан байна.  Төсөл хэрэгжих бүхий л хугацаанд бий болгосон зохион байгуулалтын бүтэц, түүний дотор мэргэжилтнүүдийг хэвээр хадгалж ажиллуулна.	ЦХХХЯ, ТХН

1.2	<p><b>БАЙГАЛЬ ОРЧИН БА НИЙГМИЙН ҮНЭЛГЭЭ</b></p> <p>Банкинд хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг төсөлд зориулан бэлтгэж, улмаар тухай бүр шинэчлэл хийж, баталгаажуулан хэрэгжүүлнэ.</p>	<p>БОНУ-нд тусгагдсан нөлөөллийг бууруулах бүх арга хэмжээг Төсөл хэрэгжих бүхий л хугацаанд авч хэрэгжүүлнэ.</p> <p>Техник туслалцааны (ТТ) үйл ажиллагааг байгаль орчин, нийгмийн талаас нь авч үзэж үнэлэх буюу шалгах шаардлагатай бөгөөд ТТ-ны ажлын удирдамжид байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үнэлэх, БОН-ийн нөлөөллийн үр дагаврыг БОНХ-нд нийцсэн байдлаар, ТТ-ны үр дүнгийн нэг хэсэг болгон бууруулахаар санал болгосон арга хэмжээний талаар тусгана.</p>	ЦХХХЯ, ТХН
1.3	<p><b>УДИРДЛАГЫН АРГА, ХЭРЭГСЛҮҮД</b></p> <p>Аливаа санал болгосон үйл ажиллагааг төсөлд зориулж бэлтгэсэн Байгаль орчин, нийгмийн арга хэрэгслийн дагуу хянасны дараа шаардлагатай бол, Байгаль орчны асуудлаар баримтлах журам (БОАБЖ), Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ), Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журмыг (ХХЗЖ) Банкинд хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшинд боловсруулж, батлуулан хэрэгжүүлнэ.</p>	<p>БОАБЖ, ТОХТ, ХХЗЖ-ыг төсөл хэрэгжих бүхий л хугацааны туршид мөрдлөг болгоно. БОН-ийн баримт бичгүүдийг Банк баталсаны дараа төсөл хэрэгжих бүхий л хугацааны туршид мөрдлөг болгож ажиллана.</p>	ЦХХХЯ, ТХН
1.4	<p><b>ГЭРЭЭТ АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧТЭЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦАА ЗОХИЦУУЛАЛТ</b></p> <p>Зохих хэрэгцээнээс үүдэлтэй барилгын бага хэмжээний ажилд гүйцэтгэгч/туслан гүйцэтгэгчийг хязгаарлагдмал биет ажил гүйцэтгүүлэхээр төслийн үйл ажиллагаанд оролцуулж болно. БОН-ийн асуудалтай холбоотой баримт бичгүүд, эсхүл төлөвлөгөө болон Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журам зэргийг багтаасан БОНХТ-ний холбогдох асуудлуудыг гэрээт ажил гүйцэтгэгчтэй хийх худалдан авалтын баримт бичгийн БОНЭМАА-ны шаардлагуудад нэгтгэнэ. Цаашид гэрээт ажил гүйцэтгэгч байгуулсан гэрээний БОНЭМАА-ны шаардлагуудыг мөрдөж ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.</p>	<p>Барилга байгууламжийг шинэчлэн сайжруулах тендерийн ажил гүйцэтгэгчид Худалдан авах ажиллагааны баримт бичгийг бэлтгэхийн өмнө БОН-ийн арга хэрэгслийг нэгтгэсэн байх ёстой.</p> <p>Гэрээний биелэлтийг төсөл хэрэгжих бүхий л хугацааны туршид хянана.</p>	ЦХХХЯ, ТХН
<b>БОНС 2: АЖИЛЛАХ ХҮЧ БА ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ</b>			
2.1	<p><b>ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ</b></p> <p>Төсөлд зориулан боловсруулсан Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журам (ХХЗЖ)-ыг шинэчлэн боловсруулж, батлуулан хэрэгжүүлнэ.</p>	ХХЗЖ-ыг шинэчилж, БОНХТ-нд тусгана.	ЦХХХЯ, ТХН

2.2	<b>ТӨСЛИЙН АЖИЛТНУУДЫН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ БУЮУ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ</b> БОНС 2-т нийцсэн, төслийн ажилтнуудын өргөдөл гомдлыг барагдуулах механизмыг ХХЗЖ-ын дагуу бий болгож ашиглана <sup>1</sup> .	Хөдөлмөрийн харилцаатай холбоо бүхий өргөдөл гомдол барагдуулах механизмыг ХХЗЖ-ыг шинэчлэх хүрээнд шинэчилнэ. Аливаа өргөдөл гомдол, түүнтэй холбогдуулан гаргасан шийдвэрийг төслийн ээлжит тайланд тусгах замаар баримтжуулна.	ЦХХХЯ, ТХН
2.3	<b>ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН (ХАБЭА) АРГА ХЭМЖЭЭ</b> ХХЗЖ-г боловсруулах явцад тодорхойлсон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) арга хэмжээг төсөл хэрэгжих явцад боловсруулж, батлуулан хэрэгжүүлнэ.	Төсөл хэрэгжих бүхий л хугацааны түршид	ЦХХХЯ, ТХН
<b>БОНС 3: НӨӨЦИЙГ ҮР АШИГТАЙ АШИГЛАХ, БОХИРДЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БА УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТ</b>			
3.1	<b>НӨӨЦИЙГ ҮР АШИГТАЙ АШИГЛАХ, БОХИРДЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БА УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТ:</b> Нөөцийг үр ашигтай ашиглах, бохирдлоос урьдчилан сэргийлэх ба удирдлага зохицуулалтын арга хэмжээг дээрх 1.3 -д заасан үйл ажиллагааны хүрээнд бэлтгэж, БОАБЖ-д тусгана.	ХХЗЖ болон БОАБЖ-ыг боловсруулж, хэрэгжүүлэх ижил цаг хугацаанд	ЦХХХЯ, ТХН
<b>БОНС 4: НУТГИЙН ИРГЭД, БҮЛГИЙН ЭРҮҮЛ МЭНД БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ</b>			
4.1	<b>ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНД БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ:</b> Төслийн үйл ажиллагаанаас үүдэн иргэд, олон нийтэд учирч болзошгүй тодорхой эрсдэл болон нөлөөллийг үнэлэх, зохицуулах арга хэмжээ болон үйл ажиллагааг боловсруулан, батлуулж, хэрэгжүүлэх ба үүнд төслийн ажилтнуудын зан үйл, онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ зэрэг орох бөгөөд эдгээр арга хэмжээг Банкинд зөвшөөрөгдөх хэмжээнд боловсруулах ХХЗЖ болон БОАБЖ-д тусгана.	ХХЗЖ болон БОАБЖ-ыг боловсруулж, хэрэгжүүлэх ижил цаг хугацаанд  Аливаа худалдан авах ажиллагааны баримт бичгийг бэлтгэхээс өмнө төслөөс санхүүжүүлэх олон нийтийг хамарсан уулзалт, хурал/чадавхийг бэхжүүлэх ажлын удирдамжид Дэлхийн банкны Байгаль орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын зааварчилгаа, түүнчлэн ДЭМБ-ын КОВИД-19-тэй холбоотой эрүүл мэндийн удирдамжид үндэслэгдсэн ХАБЭА-н шаардлага, арга хэмжээг тусгасан байх ёстой.	ЦХХХЯ, ТХН
<b>БОНС 5: ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТ, ГАЗАР АШИГЛАЛТЫН ХЯЗГААРЛАЛТ БА АЛБАДАН НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ</b>			
БОНС 5 уг төсөлд хамааралгүй.			
<b>БОНС 6: БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ БА АМЬД БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ УДИРДЛАГА</b>			

<sup>1</sup> УХААЛАГ Засаг төслийн хүрээнд бий болгосон Гомдол барагдуулах механизмыг үргэлжүүлэн ашиглана.

БОНС 6 уг төсөлд хамааралгүй.			
<b>БОНС 7: НУТГИЙН УУГУУЛ ИРГЭД/ӨМНӨД АФРИКИЙН САХАРЫН ҮЕ ДАМЖИН ОРХИГДСОН НУТГИЙН ИРГЭД, ИРГЭДИЙН БҮЛЭГ</b>			
7.1	<b>НУТГИЙН УУГУУЛ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ:</b> Нийгмийн нөлөөллийн үнэлгээг (ННҮ) хийн, баталж, БОНС 7-д нийцүүлэн, Банкинд хүлээн зөвшөөрөгдөх түвшинд боловсруулсан Талуудын оролцоог хангах төлөвлөгөөг (ТОХТ) хэрэгжүүлнэ.	Төслийн бэлтгэл ажил хангах болон төсөл хэрэгжих бүхий л хугацааны туршид	ЦХХХЯ, ТХН
7.2	<b>ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ:</b> БОНС 10-т шаардсаны дагуу нутгийн уугуул иргэдэд зориулсан гомдол барагдуулах буюу хянан шийдвэрлэх механизмыг боловсруулж, батлан мөрдөж ажиллана.	Төсөл хэрэгжих бүхий л хугацааны туршид	ЦХХХЯ, ТХН
<b>БОНС 8: СОЁЛЫН ӨВ</b>			
БОНС 8 уг төсөлд хамааралгүй.			
<b>БОНС 9: САНХҮҮГИЙН ЗУУЧЛАЛ</b>			
БОНС 9 уг төсөлд хамааралгүй.			
<b>БОНС 10: ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ БА МЭДЭЭЛЛИЙГ ИЛ ТОД БОЛГОХ</b>			
10.1	<b>ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨГ БЭЛТГЭХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ</b> Талуудын оролцоог хангах төлөвлөгөөг (ТОХТ) шинэчлэн, баталж, хэрэгжүүлнэ.	Төслийн бэлтгэл ажил хангах болон төсөл хэрэгжих бүхий л хугацааны туршид	ЦХХХЯ, ТХН
10.2	<b>ТӨСЛИЙН САНАЛ ГОМДОЛ БАРАГДУУЛАХ БУЮУ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ:</b> Санал, гомдол барагдуулах механизмыг ТОХТ-нд тусгасны дагуу бий болгож, батлан хэрэгжүүлнэ.	Төсөл хэрэгжих бүхий л хугацааны туршид	ЦХХХЯ, ТХН
<b>ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ (СУРГАЛТ)</b>			
1	ТХН-ийн ажилтнууд, төслийн үр шимийг хүртэгч гол оролцогч талууд, зөвлөхүүд, гэрээт ажил гүйцэтгэгчид, иргэд, олон нийт, төслийн ажилтнуудад зориулан дараах сургалтуудыг зохион байгуулна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн хүрээ (БОНХ)-ний бодлого, хэрэгжилтийн явц болон БОНХТ, ТОХТ, БОАБЖ болон ХХЗЖ-д анхаарал хандуулсан БОН-ийн асуудлаарх баримт бичгүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой удирдамж;</li> </ul>	Зээл хүчин төгөлдөр болсоны дараа, төсөл хэрэгжих бүхий л хугацааны туршид	Банкны болон мэргэшсэн олон улсын болон үндэсний зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр ЦХХХЯ

	<ul style="list-style-type: none"> <li>ГБМ-ыг багтаасан БОНХТ, ТОХТ, БОАБЖ болон ХХЗЖ-ын төлөвлөлт, хэрэгжилтийн талаар тусгайлсан сургалт</li> <li>Гэрээт ажил гүйцэтгэгчдийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих гэх мэт</li> </ul>		
2	Төслийн ажилтнуудад зориулан хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, үүний дотор онцгой байдлын үед урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг зохицуулах асуудал, жендер болон хүртээмжтэй байдлын талаарх суурь мэдлэг, ойлголт олгох, нутгийн иргэд, олон нийт болон байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулахтай холбоотой эрчим хүчний хэрэглээг бууруулах болон хог хаягдлын цахим менежментийн шилдэг туршлага, ГБМ-ын горим журам болон ЖСХ, КОВИД-19 болон бусад халдварт өвчинтэй холбоотой нийгмийн бусад асуудлууд гэх зэрэг сэдвээр сургалт зохион байгуулна.	Төсөл хэрэгжих бүхий л хугацааны туршид	ЦХХХЯ, ТХН